



БАГАНУУР ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд
чиглэсэн сурталчилгаа зөвлөн туслах
үйлчилгээний зардлын төсвийг батлах тухай

Монгол улсын төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.14.3 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 469 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн тушаах нь:

1. Тус газраас “Багануур Тохижилт” ААТҮГ-н нийт ажилтан албан хаагчид, дүүргийн үйлдвэр эрхэлдэг жижиг аж ахуйн нэгжүүдэд нийгмийн даатгалын үйлчилгээ, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бууруулах ХАБЭА-н мэдлэг олгох сургалтын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, санхүүгийн төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах бичиг хэргийн зардал 786,130 (Долоон зуун наян зургаан мянга нэг зуун гуч) төгрөгийн зардал гаргахыг Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч (Г.Батболд)-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтыг чанартай зохион байгуулж ажиллахыг хэлтсийн дарга нарт, ажлын тайланг 2026 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлэхийг Санхүү бүртгэл, хамралт орлогын хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч (Г.Батболд)-д, олон нийтэд мэдээлж сурталчлах, сургалтыг зохион байгуулах ажлыг Мэдээлэл технологи, сургалт, сурталчилгааны ажилтан (Г.Сүхболд)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хяналтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Мөнхцолмон)-д үүрэг болгосугай.


ДАРГА



Р.ӨНӨРЖАРГАЛ

54

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын
газрын даргын 2026 оны ...⁰⁵ дугаар
сарын ...²⁵...-ны өдрийн 1/09 дүгээр
тушаалын нэгдүгээр хавсралт



СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Сэдэв: Нийгмийн даатгалын үйлчилгээг сурталчлах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н мэдлэг олгох

Нэг. Сургалтын үндэслэл, шаардлага

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, даатгуулагч болон ажил олгогчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх эрсдэл өндөртэй “Багануур Тохижилт” ААТҮГ-ын нийт ажилтан, албан хаагчид болон дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэл эрхлэгч жижиг аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н стандартыг хэвшүүлэх, нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх зорилгоор энэхүү сургалтыг зохион байгуулна.

Хоёр. Сургалтын зорилго

• Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн шинэчлэл, даатгуулагчийн эрх, үүргийн талаар цэгцтэй мэдээлэл өгөх;

• Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан нөхцөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга замуудыг таниулах;

• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) соёлыг ажлын байранд төлөвшүүлж, холбогдох мэдлэг, чадварыг олгох.

Гурав. Хугацаа, хамрах хүрээ, зохион байгуулалт

Хэзээ: 2026 оны 5 дугаар сарын 26, 27-ны өдөр

Хаана: “Багануур Тохижилт” ААТҮГ-н хурлын зааланд, дүүргийн аж, ахуй нэгжүүдэд
Зохион байгуулагч: Нийгмийн даатгалын газрын албан хаагчид

Дөрөв. Сургалтын хөтөлбөр

Хугацаа	Үйл ажиллагаа / Хичээлийн сэдэв	Хариуцах эзэн / Лектор	Тэмдэглэл
07:50 - 08:00	Бүртгэл, сургалтын материалыг тараах	Зохион байгуулах баг	Танхимд
08:00 - 08:10	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн шинэчлэл, үйлчилгээ, даатгуулагчийн эрх ба үүрэг, даатгалын хувь, хэмжээ	Хамралт орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч	PPT

		мэргэжилтэн Ц.Солонго	
08:10 – 08:20	Тэтгэвэр, тэтгэмжийн талаарх мэдээлэл, Сайн дурын даатгалын мэдээлэл	Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн дарга Д.Хэрлэн	PPT
08:20 - 08:30	Хөдөлмөрийн чадвар алдалтын талаарх ерөнхий ойлголт	Магадлагч эмч, мэргэжилтэн Б.Балжинням	PPT
08:30 – 08:40	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх нь	Нийт албан хаагчид	Хэлэлцүүлэг
14:00- 16:00	Аж ахуйн нэгжүүдээр орж мэдээлэл хүргэх.	А. Г.Сүхболд, Б.Балжинням Б.Т.Сэржмядаг А.Ундармаа	Мэдээлэл хүргэх, санал солилцох

Тав. Хүлээгдэх үр дүн

“Багануур Тохижилт” ААТҮГ, аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудын нийгмийн даатгал болон ХАБЭА-н хууль эрх зүйн мэдлэг дээшилнэ.

Ажлын байрны эрсдэлийг илрүүлэх чадвар сайжирч, үйлдвэрлэлийн осол, бэртэл гэмтлийн тоо буурна.

Ажил олгогч болон ажилтны хоорондын харилцан ойлголцол нэмэгдэж, хөдөлмөрийн аюулгүй орчин бүрдэнэ.


Сайн дурын даатгал болон албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлнэ.

Зургаа. Санхүүжилт

Сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг батлагдсан санхүүгийн төлөвлөгөөний (Хавсралт 2)-н дагуу Нийгмийн даатгалын газрын холбогдох төсвөөс санхүүжүүлнэ.

ХЯНАСАН:


ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:



Н.МӨНХЦОЛМОН


БОЛОВСРУУЛСАН:

ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН:



А.УНДАРМАА

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын
газрын даргын 2026 оны ...⁰⁵... дугаар
сарын ...²⁵...-ны өдрийн ^{1/09} дүгээр
тушаалын хоёрдугаар хавсралт



СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ

Д/д	Сургалтын хэрэглэгдэхүүн	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /Төг/	Нийт дүн / төг/
1	AI эрх 2026.05.25-2026.06.26	1 эрх	19\$	66,880
2	Цайны зардал (Кофе, аарц, нэг удаагийн аяга халбага, сүү)	150	2100	315,000
3	A4 цаас	3	20,000	60,000
4	ХАБЭА-н хөтөлбөр гарын авлага хэвлүүлэх	150	2295	344,250
Нийт				786,130

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:

Н.МӨНХЦОЛМОН

БОЛОВСРУУЛСАН:
ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН:

А.УНДАРМАА